

**“ШУДРАГА ЁС ХӨГЖИЛ ДЭВШИЛД ХАМТДАА” АЯНЫ ХҮРЭЭНД
ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРААС
ЗОХИОН БАЙГУУЛСАН АЖЛЫН ТАЙЛАН**

2022.12.20

Сайнцагаан сум



Авлигын эсрэг олон улсын өдрийг угтан аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг даргын тамгын газартай хамтран зохион байгуулж байгаа **“Шудрага ёс хөгжил дэвшилд хамтдаа”** аянд тус байгууллага 2022 оны 12 дугаар сарын 17-ны өдрөөс 12 дугаар сарын 24-ний өдөр хүртэлх хугацаанд нэгдэж, иргэд, олон нийтэд болон тус байгууллагын албан хаагчдад авлигын нийгэм, эдийн засгийн хор хөнөөлийг таниулах, шудрага ёсны үзлийг төлөвшүүлэх, авлигын эсрэг дуу хоолойгоо нэгтгэх үйл ажиллагааг зохион байгууллаа.

“Шудрага ёс хөгжил дэвшилд хамтдаа” аяны хүрээнд:

- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3-р бүлэг “Албан тушаалтанд тавигдах хориглолт, хязгаарлалт” сэдвээр сумдын Газрын даамлуудад цахим сургалт зохион байгуулж, дээрх сэдвийн хүрээнд санал солилцсон. Сургалтад 13 сумын Газрын даамал хамрагдсан.

- Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт авлигын хор аюулыг олон нийтэд тайлбарлан таниулах, мэдээлэл сурталчилгаа явуулах үүргийг аж ахуй нэгж, байгууллагууд хүлээсэн байдаг.

Иргэд, олон нийтийг соён гэгээрүүлэх зорилгоор олон талт арга хэмжээнүүдийг үе шаттай зохион байгуулж байгууллагын мэдээллийн самбар, цахим хуудас, фэйсбүүк хуудсанд мэдээллийг байршуулж олон нийтэд сурталчилан ажиллаж байна. Авлигатай тэмцэх газраас хийсэн богино хэмжээний видео, шторкыг байгууллагын www.dundgovi.gazar.gov.mn цахим хуудсанд, байгууллагын коридорт байрладаг “Цахим мэдээллийн дэлгэц”-ээр болон “Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар” гэсэн facebook хуудсанд байршуулж, албан хаагчид хувийн facebook хуудсандаа хуваалцаж олон нийтэд сурталчилсан.



- Байгууллагын логон дээр гомдол мэдээлэл хүлээн авах 110 дугаарыг **сурталчилсан наалтыг** хэвлүүлж өрөөнүүдийн гадна болон албан хаагчдын компьютер дээр нааж тус байгууллагаар үйлчлүүлж байгаа иргэдэд сурталчилсан.



- Авлигын эсрэг хуулийг сурталчилсан 4 төрлийн тараах материалыг өнгөтөөр 100 ширхэгийг хэвлэн олшруулж, бүх албан хаагчдын өрөөнд байршуулан тус байгууллагаар үйлчлүүлсэн иргэдэд тараасан.

Газрын кадастрын цахим систем болох www.egazar.gov.mn сайтыг сурталчлах иргэдэд зориулсан **гарын авлага** дээр авлигын гомдол мэдээлэл хүлээн авах 110 дугаарыг сурталчилсан.



- Авлигын эсрэг олон улмын өдрийг тохиолдуулан байгууллагын албан хаагчдын дунд асуулт хариултын “АХА” танин мэдэхүйн хөгжөөнт тэмцээнийг зохион байгуулсан ба авлига, ашиг сонирхлын хүрээнд асуултуудыг бэлтгэж, зохион байгуулснаараа онцлог байлаа. Тэмцээний 1-р байранд Газрын удирдлагын хэлтсийн дарга Б.Рэнцэндорж, 2-р байранд Газар зохион байгуулалтын төлөвлөлт, өмчлөлийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн Т.Саранзул нар тус тус шалгарч, гарын бэлэг гардуулсан.




- Тус байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааг иргэд, олон нийтэд сурталчлах “Шударга ёс хөгжил дэвшилд-110” мэдээллийн самбарын мэдээллийг тогтмол ажиллуулж байна.

- Байгууллагын дотоод хяналтын нэгж байгууллагын цахим хуудас болох www.dundgovi.gazar.gov.mn хаягийн үйл ажиллагаанд Засгийн газрын 2021 оны 374 дүгээр тогтоолын 9 дүгээр хавсралтын дагуу байгууллагын ил тод байдлын шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа эсэхэд дотоод хяналт хийж гүйцэтгэсэн.



Байгууллагын цахим хуудасны бүтэц, зохион байгуулалтад өөрчлөлт оруулж, дээрх тогтоолын дагуу ил тод байдлын мэдээллийг агуулгын хүрээнд шинэчлэх талаар хариуцсан албан хаагчид зөвлөмж өгсөн.



Тус байгууллагын албан хаагчид “Шударга ёс, хөгжил дэвшилд хамтдаа” уриалгад нэгдэж байна.

ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР